



ГОВЬСУМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 1175

Шивээговь сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.1.1, 7 дугаар зүйлийн 7.3, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “Сумын 2021 оны төсөв батлах тухай” 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ НЬ:**

1. Сумын 2021 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хийгдэх “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өрөөний тохижилт” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Ч.Сугармаа

(Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга:

Э.Халиун

(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Гишүүн:

А.Эрдэнэчулуун

(Ашиглагч байгууллагын төлөөлөгч)

2. Худалдан авах ажлыг захиалагчаас гаргасан ажлын даалгаврын дагуу шаардлагад нийцсэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн дарга /Ч.Сугармаа/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

42121-430